


**ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР**

“Компанийн тухай хууль”-ийн 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлийг үндэслэн Компанийн хувь нийлүүлэгч “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалаар 30 000 000 000 /гучин тэрбум/ төгрөгийн үнэ бүхий, нэг бүр нь 10 000 /арван мянга/-н төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3 000 000 /гурван сая/ ширхэг, “Мах бонд”-ыг жилийн хүү нь 16.2 хувь байх, 90 хоног тутам хүү төлөх нөхцөлтэй гаргахаар шийдвэрлэсэн.

Тушаалын эх хувь:



Үнэт цаас гаргах шийдвэр нь хууль, эрх зүйн хүчин төгөлдөр эсэх талаарх хуулийн компанийн дүгнэлт:



Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т **“Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн бичиг гаргах шийвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана. Энэ шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана.”** гэж хуульчилсан байна. “Жаст Агро” ХХК-ийн дүрэмд зааснаар тус компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөлгүй учир өрийн бичиг буюу бонд гаргах шийдвэрийг Хувь нийлүүлэгчдийн хурал буюу Компанийн тухай Монгол Улсын хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д **“... Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.”** гэж заасны дагуу “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирал гаргасан. “Мах бонд” гаргах тухай “Жаст групп” ХХК-ийн 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаалд өрийн бичиг буюу бондын нэр, хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх нөхцөл зэргийг зааж өгсөн байна.

Иймд “Мах бонд” гаргах тухай “Жаст Агро” ХХК-ийн хувьцаа эзэмшигч “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захиралын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/19 дугаар тушаал нь Үнэт цаасны тухай Монгол Улсын хууль, Компанийн тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжинд нийцсэн байна.

